

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны ... дугаар  
сарын ... - ны өдөр

Дугаар:

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь заалт, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам"-ын 1.6, 3.3.4, 4.1, 4.2, 4.3, 5.3, 6.12 дахь заалтуудыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай.

1/ "1.6. Хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлыг Барилгын тухай хуулийн 34.1.14-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа байгууллага /цаашид "зохион байгуулагч байгууллага" гэх/ нэг цэгийн үйлчилгээгээр мэдээлэл өгч, цахим системээр хүсэлтийг хүлээн авч зохион байгуулна."

2/ "3.3.4. дээд боловсролын мэдээлэл /гадаадын их, дээд сургуульд боловсрол эзэмшсэн бол дипломыг баталгаажуулж, апостиль гэрчилгээ авсан байна./"

3/ "4.1. Хуулийн этгээдээс илгээсэн хүсэлтийг зохион байгуулагч байгууллага цахимаар хүлээн авч, дор дурдсан мэдээллийг хянаж, баталгаажуулна. Үүнд:

4.1.1. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны гэрчилгээг хүсэлт гаргасан өдрөөс сүүлийн 2 жилийн хугацаанд суралцаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам"-ын дагуу ХАБЭА-н ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллагад 124 цаг болон барилгын салбарын ХАБЭА-н ажилтан бэлтгэх 40-өөс доошгүй цагийн сургалтад суралцаж төгссөн байх;

4.1.2. энэ журмын 3.5, 4.2, 4.3, 4.5, 6.9, 7.7-д заасан мэдээлэл;

4.1.3. энэ журмын 6.1-6.5, 6.7, 6.8-д заасан шаардлага;

4.1.4. энэ журмын 1 дүгээр хавсралтын "онцгой төвөгшилтэй" барилга байгууламжын ЗТ-5.1, БА-5.1 ажлын төрлөөр тусгай зөвшөөрөл авах хуулийн этгээд нь бусад аж ахуйн нэгжтэй гэрээний үндсэн дээр хамтран хэрэгжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн асуудлаар байгуулсан гэрээ."

4/ “4.2. Хуулийн этгээд тусгай зөвшөөрлийг шинээр болон нэмэлт /энэ журмын 7.3-7.6-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд/ ажлын төрлөөр авах хүсэлт гаргасан тохиолдолд инженер, техникийн ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг сүүлийн 1 сар, сунгах хүсэлт гаргасан тохиолдолд сүүлийн 3 сар тасралтгүй төлсөн лавлагааг E-Mongolia цахим системээс авч, оруулсан байна.”

5/ “4.3. Суурь нөхцөл, шаардлагад заасан мэргэшсэн зэрэгтэй инженер, архитекторын орон тоонд зөвлөх инженерийн зэрэгтэй инженер, архитекторыг /үндсэн ажилтан бол хамаарахгүй/ бүртгэхийг хориглох ба мэргэшлийн зөвлөх зэрэгтэй инженер нь тусгай зөвшөөрөлтэй 3 хүртэлх хуулийн этгээдэд ажиллаж болох /мэргэшсэн зэргийн гэрчилгээг оруулахгүй/ ба гэрээг мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

6/ “5.3. Энэ журмын 4.1-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол энэ тухай үндэслэлийг тодорхой зааж, өргөдөл гаргагчид цахимаар мэдэгдэл илгээнэ.”

7/ “6.12. Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан хуулийн этгээдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нь салбарын инженер, техникийн ажилтан болон мэргэжилтэй ажилтан байж болно. Мөн хос мэргэжилтэй инженер, техникийн ажилтан нь тухайн хуулийн этгээдэд өөрийн эзэмшсэн хос мэргэжил тус бүрээр бүртгэгдэх боломжтой.”

2. Мөн журамд доор дурдсан агуулгатай дараах заалтуудыг нэмсүгэй.

1/ “6.8.5. инженер, техникийн ажилтнуудыг цахимаар дахин хүсэлт илгээн баталгаажуулах.”

2/ “6.13. Энэ журмын 1 дүгээр хавсралтын “Онцгой төвөгшилтэй” барилга байгууламжын ЗТ-5.1, БА-5.1 ажлын төрлөөр тусгай зөвшөөрөл авах хуулийн этгээд нь бусад аж ахуйн нэгжтэй гэрээний үндсэн дээр хамтран хэрэгжүүлэх тохиолдолд тус тусын байвал зохих инженер, техникийн ажилтныг бүртгүүлж, суурь нөхцөл, шаардлагыг ханган тусгай зөвшөөрлийг авч болно.”

3/ “6.14. Бусад салбарын мэргэшсэн зэргийн гэрчилгээг барилгын салбарын мэргэшсэн зэргийн гэрчилгээнд дүйцүүлэн тооцохыг хориглоно. ”

4/ “7.7. Газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх хуулийн этгээд нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасны дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар мэргэжлийн дүгнэлт гаргуулсан байна.”

3. Мөн журмын 2.1.7, 5.5 дахь заалтыг хассугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д үүрэг болгосугай.